134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		<b>-</b>	14,793,329,477.00	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАС</b>	<b>1,076,815,800.00</b>	<b>976,525,268.02</b>	<b>(100,290,531.98)</b>	<b>90.69</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		<b>-</b>	441,164,393.00	441,164,393.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		<b>-</b>	535,360,875.02	535,360,875.02
<b>122</b>	<b>Тусlamжийн эх үүсвэрээс санхүүжих</b>	<b>15,095,430,900.00</b>		<b>-</b>	<b>(15,095,430,900.00)</b>
1220	Тусlamжийн эх үүсвэрээс санхүүжих	15,095,430,900.00		<b>-</b>	<b>(15,095,430,900.00)</b>
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			32,252,202.03	32,252,202.03
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>			<b>1,642,702,558.56</b>	<b>1,642,702,558.56</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		<b>-</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>275</b>	<b>357</b>	<b>82</b>	<b>129.8</b>
620001	Удирдах ажилтан	5	5		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	248	357	109	143.9
620003	Үйлчлэх ажилтан	20	29	9	145.0
620004	Гэрээт ажилтан	2	7	5	350.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00
210604	Урсгал засвар	16,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,000,000.00
131103	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэл дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Нийслэлийн Эрүүл мэндийн газрын бодлого чиглэл, шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих, хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх” чиг үүрэг бүхий Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллага юм.

Тус эмнэлэг нь “Ур чадварт суурилсан эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх, эмнэлгийн орчныг боловсронгуй болгох, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох замаар хүн амын эрүүл мэндийг дэмжих” гэж зорилго тавин ажиллаж байна.

#### 3.2 БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧИН

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бodoх бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.3 дахь заалт “Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах”
- Эрүүл мэндийн хуулийн 7.1.1 дэх заалт “төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/139 тоот “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг шинжилгээ оношилгоо”-г зохион байгуулах журам
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 10 тоот тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоол, “Журам шинэчлэн батлах тухай” 02 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бodoх бүртгэлийн стандарт, холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2020-2021 оны үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн Дотоод аудитын албанаас 2022 оны 5 дугаар сард аудит, хяналт шалгалтыг хийж тесөл хөтөлбөрийн хэрэгжилт, засвар үйлчилгээ, худалдан авах ажиллагаатай холбоотой засварын ажил гүйцэтгэх гэрээний хугацааны алданги, магадалшгүй ажлын зардлыг илүү олгосон, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” А/837 дугаар захирамжаар үзлэг хийх шаардлагатай материалын зардлаас цалин урамшуулал болгож авсан 5,503.8 мянган төгрөгийг буцаан

төлүүлэхээр улсын байцаагчийн актуудыг тус тус үйлдэж, 2,663,547.5 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаанд зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,663,912.9 мянган төгрөгөөр буюу 22.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	32,252.2	1,642,702.6	1,610,450.4
Авлага	3,064,860.5	1,359,506.8	(1,705,353.7)
Урьдчилгаа	4,639.5	4,110.4	(529.1)
Бараа материал	1,509,821.1	1,892,527.5	382,706.4
Үндсэн хөрөнгө	7,262,546.8	9,427,082.3	2,164,535.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,874,120.0</b>	<b>14,325,929.5</b>	<b>2,451,809.5</b>
Өр төлбөр	629,061.1	-	(629,061.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,245,058.9	14,325,929.5	3,080,870.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>11,874,120.0</b>	<b>14,325,929.5</b>	<b>2,451,809.5</b>

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,642,702.6 мянган төгрөг болж 1,610,450.4 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт хийгдсэнээс шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 1,359,506.8 мянган төгрөг болж 1,705,353.7 мянган төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага болох ЭМДЕГ-аас санхүүжилтээ авсантай холбоотой байна. Авлагын дансны үлдэгдэл он удаан жил болсон авлага байхгүй байна. Дээрх авлагууд нь тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Бараа материал 380,946.4 мянган төгрөгөөр өссөн нь КОВИД-19 цар тахлын бэлтгэл хангах үүднээс эм, боох материалын 2 сарын нөөц татан авалт хийснээс болсон байна. Бараа материалын үлдэгдэлд ашиглалтгүй, хугацаа нь дууссан эм, эмийн хэрэгсэл, бараа материал байхгүй гэж тооллогын бүртгэл, тайлан гаргасан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,427,082.3 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 2,164,535.6 мянган төгрөг буюу 29.8 хувиар өссөн байна. Энэ нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 10,862.2 мянган төгрөгийн, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,626,587.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө тус тус нэмэгдсэн байна.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2022 оны 8 дугаар сарын 26-ны А/285 тоот тушаалаар 159,009.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй сурьеэгийн диспансерийн барилгыг акталсан байна. Мөн шилжүүлсэн үндсэн хөрөнгийн гүйлгээ гаргаагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 629,061.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээ хугацаанд нь авч чадаагүйгээс хойшлогдсон цахилгааны төлбөр 12,020.0 мянган төгрөг, эм боох хэрэгслийн төлбөр 236,420.5 мянган төгрөг, урсгал засварын өглөг 2,317.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 378,303.4 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулснаас шалтгаалжээ. 2022 оны жилийн эцсээр өр төлбөрийн үлдэгдэлгүй байсан болно.

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгө 8,016,638.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 976,184.0 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 16,000.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээр 13,047,967.6 мянган төгрөгийг тус тус хүлээн авч нийт 22,056,790.3 мянган төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэн орлого үр дүнгийн тайлангаар тайлагнасан байна. Нийт орлого өмнөх оноос 6,364,994.1 мянган төгрөгөөр буюу 140.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 46,183,841.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 2022 онд КОВИД-19 цар тахлын тархалт буурснаас шалтгаалан эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт өмнөх оноос 43,393,238.9 мянган төгрөгөөр багассанаас голлон шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо 3,080,870.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 15,095,430.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,076,815.8 мянган

төгрөг, нийт зарлагыг 16,371,228.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,076,815.8 мянган төгрөг, тусlamжийн үйлчилгээнээс 15,095,430.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр нийт 16,371,228.9 мянган төгрөгөөр төсвийн төслийг баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт болон орон тоог нэмэгдүүлээгүйтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 30 зорилт, 115 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 16,371,228.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 15,611,013.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 760,215.4 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 14,793,329.5 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 976,525.2 мянган төгрөг, нийт 15,769,854.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 14,175,404.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,175,404.4 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 646,822.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 63,340.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 1,223,371.1 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 281,012.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 16,000.0 мянган төгрөгийн санхүүжилт орсныг сурьеэгийн шинжилгээний аппарат засварын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх	25,697.5	25,697.5	-	100.0%
2	Бага насны хүүхдийн хоол тэжээлийн тусlamжийн тасралтгүй байдлыг хангах, хоол тэжээлийн дутлаас сэргийлэх, илрүүлэх эмчлэх	51,427.0	19,427.0	(32,000.0)	100.0%
3	Хүүхдийн өвчний цогц менежмент	32,277.0	32,277.0	-	100.0%
4	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтны хувцас	41,500.0	41,500.0	-	100.0%
5	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтны сургалт	21,918.0	-	(21,918.0)	-
6	Сурьеэгийн шинжилгээний аппарат засвар	16,000.0	16,000.0	-	100.0%
	Дүн	188,819.5	134,901.5	(53,918.0)	

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь 2022 онд Юнисеф Олон улсын байгууллагаас зохион байгуулж, санхүүжүүлсэн 5 арга хэмжээнд хамрагдсан байна. Мөн Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс ашиглалтын явцад гэмтсэн сүрьеэгийн шинжилгээний аппаратыг засварлуулах арга хэмжээг авч бүрэн засварласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт, хөрөнгийн бүртгэл, шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн ахлах аудитор Ж.Эрдэнэбилэг, аудитор Д.Мэндбаяр, аудиторын туслах Θ.Дэлгэрмаа, Б.Энхчимэг нар гүйцэтгэж, хяналтыг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн захирал Д.Энхбаатар, НТАГ-ын Санхүү-нийцлийн хэлтсийн аудитын менежер С.Гантэгс, Санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-д 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 78 тоот албан бичгээр, хуулийн хугацааг 14 хоног хоцроож ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн байдлын тайланг, суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгийн 11,874,120.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 237,482.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 166,237.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үед тогтоосон материаллаг байдлын сонгосон суурь үзүүлэлт 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 2,451,809.5 мянган төгрөгөөр өссөн тул гүйцэтгэх явцад материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоо шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 14,325,929.5 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 286,518.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 200,563.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор цахим гарын үсэг ашиглаж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд тайлант хугацаанд 646,822.7 мянган төгрөгийн цалин, шимтгэлийн зардал, 5,334.2 мянган төгрөгийн шатахууны зардал, 4,775.2 мянган төгрөгийн шуудан холбоо, интернэтийн зардлын хэмнэлтийг бий болгожээ.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 18 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд нийт 175 мэдээлэл байршуулахаас 168 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, хугацаанд нь байршуулж, 1,825,225.2 мянган төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 4 мэдээлэл ил тод мэдээлээгүй ба шалгалтын явцад нөхөж мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.2 “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнө оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дун бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”, 6.4.8 “...,төсөө, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, СТОУС-ын 1 “Тайлангийн толилуулга” ... үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг стандартад заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг...” заалтуутдай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хугацаа хоцроож мэдээлсэн асуудал дахин давтагдсан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 2022 онд 10,862.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 2,892,504.4 мянган төгрөгийн бараа материал, 1,925,992.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг худалдан авсан нь Засгийн газрын 124 дугаар тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай” -той нийцэж байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл, бараа материалын тооллогыг явуулах, хөрөнгийн ашиглалтын чанар байдлыг үнэн зөв тодорхойлох, актив дансыг улайлгаж гүйлгээ хийснийг запруулах, бүтэц орон тоог ажлын гүйцэтгэлтэй уялдуулан зөв тодорхойлж дээд шатны байгууллагаар бүтэц орон тоог шинэчлэн батлуулах талаар зөвлөмж өгсөн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,711,400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн бөгөөд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг биелүүлж ажилласан ч хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт			/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Албан шаардлага	4	2,711,400.0	4	-	60.0
Нийт дүн	6	2,711,400.0	6	-	80.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Байгууллагын 2018 онд батлагдсан бүтэц, орон тоог шинэчлэн батлуулсан эсэх
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
- Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдсэн эсэх

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,825,225.2 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс 1 зөрчилд албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь НЭМГ-ын даргын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/11 тоот тушаалаар батлагдсан бүтэц орон тооноос 82 ажилтны орон тоог хэтрүүлэн ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 "...төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тогтоох", 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" заалтуудтай нийцээгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /марсан, тэмдэглээгүй орхисон/.

**Өгсөн зөвлөмж:** Зөрчлийг арилгах зөвлөмж өгөв. Бүтэц орон тоог шинэчлэн батлуулах саналыг бэлтгэн холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх. Батлагдсан орон тооны хязгаарт ажиллаж байх

## 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 *Илрүүлэлт* Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, анхны өртгөө нөхсөн нийт 1,951,914.7 мянган төгрөгийн 1,080 ширхэг үндсэн хөрөнгө байна. Тооллогын бүртгэлээр тус хөрөнгүүдийн чанар байдлыг тодорхойлоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшшилцөн тогтоох;" УСНББОУС-17 14 дүгээр зүйл Хүлээн зөвшөөрөлт "Үндсэн хөрөнгийн өртгийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө ...б.Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхыг найдвартай хэмжиж чадах...", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1 "Төрийн өмчтүү хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг бодит үнэ цэнээр шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс /мянган төгрөгөөр/	
	Тоо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн
2022 оны санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өргөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа 1,080 ширхэг 1,951,914.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.	1	-					1	-
НЭМГ-ын даргын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/11 тоот тушаалаар батлагдсан бүтэц орон тооноос 82 ажилтны орон тоог хэтрүүлэн ажилласан	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>					<b>2</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс /мянган төгрөгөөр/					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллээс 4 мэдээлэл хугацаа хоцроож, 4 мэдээлэл шалгалтын явцад нөхөж мэдээлсэн	1	1,825,225.2			1	1,825,225.2		
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>		<b>2</b>	
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>1,825,225.2</b>			<b>1</b>	<b>1,825,225.2</b>	<b>2</b>	

### АУДИТИН ТАЙЛАНГ:

**Бэлтгэсэн:**

“ЦЭБЭ Консалтинг аудит”  
ХХК-ийн захирал

Аудитор



Д.Энхбаатар

Ж.Эрдэнэбилэг